

**БАЯНТҮМЭН СУМЫН ЕБСУРГУУЛИЙН 3 ДУГААР АНГИЙН СУРАГЧДЫН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

Сурагчийн нэр:

/Нэгдмэл агуулгаар/

2023-2024 оны хичээлийн жил

А ХУВИЛБАР

НИЙТ ХУГАЦАА 60 МИНУТ

МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛ 30 МИНУТ

Эх дээр ажиллаарай.

Бор туулай яагаад цагаан болов?

Манай аавын танил Дорж гуайнх туулайн бөжин тэжээдэг байв. Хүү маань өглөө босмогц л туулайн байрны хажууд очиж зогсон, байцайны хальс, лууван зөөж идүүлэх гэж оролдоно. Ингэсээр тэр хоёр ижил дасал болж, бие биеэсээ салахаа болив. Сэрүү орж зуслангаас буух болтол тэр хоёр найзалж билээ. Харин энэ өвөл цагаан сараар Дорж гуайтай золгохоор хүүгээ дагуулж, тэднийд очив. Бөжин нь гэнэт орон дороос гарч иртэл хүү алмайртлаа гайхан бөжинг таньсангүй. "Чиний найз бөжин чинь байна шүү дээ" гэсэнд "Биш ээ биш, тэр чинь бор шүү дээ, энэ чинь цагаан юм байна" гэжээ.

1. Хүү туулай хоёр яагаад ижил дасал болов? /1 оноо/

А. Хүү туулайд хайртай болохоор

Б. Өглөө бүр туулайд байцайны хальс, лууван зөөж идүүлэх гэж оролдсоор

В. Өөрөө туулай тэжээдэг болохоор

2. Хүү туулайг яагаад таниагүй вэ? /1 оноо/

А. Зүс нь өөрчлөгдсөн тул

Б. Өөр туулай байсан

В. Хүү мартамхай зантай учраас

3. Хаврын улиралд ямар баяр болдог вэ? /1 оноо/

А. Шинэ жил

Б. Наадам

В. Цагаан сар

4. Залгаврыг зөв залган бичсэн хэсгийг сонгоорой. /1 оноо/

А. хэлэлц+нэ=хэлэлцнэ

Б. Хэлэлц+нэ=хэлэлцэнэ

В. Хэлэлц+нэ=хэллцэнэ

5. Туулай хэзээ ямар өнгөтэй дээл өмсдөг вэ? Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй. /2 оноо/

• Туулай хавар зуны улиралд дээл өмсдөг.

• Туулай өвлийн улиралд, дээл өмсдөг.

6. Ертөнцийн гурван хэцүүг гүйцээн бичээрэй. /3 оноо/


Үерлэн шуугих нь хэцүү

Дүрэлзэн асах нь хэцүү

Эрчлэн хийсэх нь хэцүү

МАТЕМАТИК ХИЧЭЭЛ 30 МИНУТ

1. Тоонд хэдэн мянгат (мян), зуут (з), аравт (а), нэгж (н) байгааг дүрсэлжээ. Тохирох тоог олж дугуйлаарай. /1 оноо/




- A. 4686 Б. 4876 В. 4786 Г. 4796

2. $912 \times 7 = ?$ Тооны утгыг олоорой. /1 оноо/

- A. 6374 Б. 6394 В. 6384 Г. 6574

3. Аль хэсгийн шулуун нь огтлолцсон бэ? /1 оноо/



4. Өгөгдсөн өгөгдлийг ажиглаад, асуултад хариулаарай. /1 оноо/

А. Туяа Болдоос хэдээр олон үсэрсэн бэ?

| № | Хүүхдийн нэр | Үсэрсэн тоо |
|---|--------------|-------------|
| 1 | Амар | 10 |
| 2 | Болд | 8 |
| 3 | Туяа | 15 |


- A. 2 Б. 5 В. 7 Г. 18

5. Өгсөн нэгжээр илэрхийлж бичээрэй. /2 оноо/

- A. $3254 \text{ г} = \dots\dots \text{ кг } \dots\dots \text{ г}$
 Б. $147 \text{ мин} = \dots\dots \text{ цаг } \dots\dots \text{ мин}$

6. Хүүхдүүд ямар зайрмагт дуртайг зурган диаграммаар харуулжээ. /3 оноо/

| | |
|-----------------|--|
| Шоколадтай | |
| Ургамлын сүүтэй | |
| Чацарганатай | |
| Нэрс жимстэй | |



A. Хэдэн хүүхэд шоколадтай зайрмагт дуртай вэ? /1 оноо/

.....
 Б. Хэдэн хүүхэд нэрс жимстэй зайрмагт дуртай вэ? /1 оноо/

.....
 В. Долоон хүүхдийн дуртай зайрмагийг нэрлэнэ үү? /1 оноо/

.....

**БАЯНТҮМЭН СУМЫН ЕБСУРГУУЛИЙН 3 ДУГААР АНГИЙН СУРАГЧДЫН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

Сурагчийн нэр:

/Нэгдмэл агуулгаар/

2023-2024 оны хичээлийн жил

Б ХУВИЛБАР

НИЙТ ХУГАЦАА 60 МИНУТ

МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛ 30 МИНУТ

Эх дээр ажиллаарай.

Ээжийн цамц

Нэгэн өдөр Сувдаа охины ээж ажил ихтэй байсан болохоор цамцаа угааж чадалгүй ажилдаа явсан байв. Тэр цамц ээжийнх нь хувцасны дотроос хамгийн гоёмсог нь байлаа. Сувдаа ээждээ туслахаар цамцыг угаав. Угаалгын машинд хийн угааж, хэцэн дээр тохлоо. Оройхон цамцаа үзтэл дүүд нь таарахаар жижиг болсон байв. Сувдаа охин сандран, цамцыг авч индүүдэн сунгаж татсан боловч том болсонгүй. Хаалга тогшиход Сувдаа ээжээсээ айгаад цамцаа нууж орхижээ.

1. Сувдаа ээжийнхээ цамцыг яагаад угаасан бэ? /1 оноо/

А. Цамцыг нь гоё болгох гэж

Б. Ээжийгээ баярлуулах гэж

В. Ээждээ туслах гэж

2. Сувдаа ямар зан чанартай хүүхэд вэ? /1 оноо/

А. Цэвэрч

Б. Ээжийгээ хайрладаг

В. Ажилсаг

3. Өвлийн улиралд ямар баяр болдог вэ?

А. Шинэ жил

Б. Наадам

В. Цагаан сар

4. Залгаврыг зөв залган бичсэн хэсгийг сонгоорой. /1 оноо/

А. харагд+на=харагдна

Б. харагд+на=харагдана

В. харагд+на=харгадна

5. Сувдаа ямар ажил хийсэн бэ? Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй. /2 оноо/

• Сувдаа цамц угаав.

• Сувдаа цамц индүүдэв.

6. Ертөнцийн гурван хэцүүг гүйцээн бичээрэй. /3 оноо/


Бой нь арилсан нэг хөөрхөн

Борвио нээсэн нэг хөөрхөн

Босож тэнцэж байгаа нэг хөөрхөн

МАТЕМАТИК ХИЧЭЭЛ 30 МИНУТ

1. Тоонд хэдэн мянгат (мян), зуут (з), аравт (а), нэгж (н) байгааг дүрсэлжээ. Тохирох тоог олж дугуйлаарай. /1 оноо/



А. 4626

Б. 4925

В. 4726

Г. 4825

2. $912 \times 5 = ?$ Тооны утгыг олоорой.

А. 4550


Б. 4660

В. 4560

Г. 4050

3. Аль хэсгийн шулуун нь зэрэгцээ шулуун бэ ?

/1 оноо/



4. Сайншанд хотын цаг агаарын хэмийг дараах хүснэгтээр үзүүлэв. Үүнийг ажиглаад, асуултад хариулаарай. /1 оноо/

А. Хамгийн дулаан өдөр хэзээ вэ?

| | | | |
|--------------------|-------------------|-------------------|--------------------|
| 11 дүгээр сарын 11 | 11дүгээр сарын 12 | 11дүгээр сарын 13 | 11 дүгээр сарын 14 |
| 6 | 5 | 3 | 4 |

А. 11-р сарын 14

Б. 11-р сарын 12

В. 11-р сарын 11

Г. 11-р сарын 13

5. Өгсөн нэгжээр илэрхийлж бичээрэй.

/2 оноо/


А. 8921 г = кг г

Б. 249 мин = цаг мин

6. Хүүхдүүд ямар зайрмагт дуртайг зурган диаграммаар харуулжээ.

/3 оноо/

| | |
|-----------------|--|
| Шоколадтай | |
| Ургамлын сүүтэй | |
| Чацарганатай | |
| Нэрс жимстэй | |



А. Хэдэн хүүхэд шоколадтай зайрмагт дуртай вэ?

/1 оноо/

Б. Хэдэн хүүхэд нэрс жимстэй зайрмагт дуртай вэ?

/1 оноо/

В. Долоон хүүхдийн дуртай зайрмагийг нэрлэнэ үү?

/1 оноо/

Зөв хариулт

| А хувилбар | | Оноо | Б хувилбар | | Оноо |
|-------------------|---------------------------------------|------|-------------------|---------------------------------------|------|
| Монгол хэл | | | Монгол хэл | | |
| 1 | Б | 1 | 1 | В | 1 |
| 2 | А | 1 | 2 | В | 1 |
| 3 | В | 1 | 3 | А | 1 |
| 4 | Б | 1 | 4 | Б | 1 |
| 5 | Бор, хүрэн Цагаан | 2 | 5 | Угаалгын машинд Индүүгээр | 2 |
| 6 | Ус Гал Салхи | 3 | 6 | Хүүхэд Гөлөг Унага | 3 |
| Бүгд | 9 оноо | | Бүгд | 9 оноо | |
| Математик | | | Математик | | |
| 1 | В | 1 | 1 | Г | 1 |
| 2 | В | 1 | 2 | В | 1 |
| 3 | А | 1 | 3 | Б | 1 |
| 4 | В | 1 | 4 | В | 1 |
| 5 | А. 3 кг 254 г Б. 2 цаг 27 мин | 2 | 5 | А. 8 кг 921 г Б. 4 цаг 9 мин | 2 |
| 6 | А. 12 Б. 3 В. Чацарганатай үрэл | 3 | 6 | А. 12 Б. 3 В. Чацарганатай үрэл | 3 |
| Бүгд | 9 оноо | | Бүгд | 9 оноо | |
| Нийт | 18 оноо | | Нийт | 18 оноо | |